PLITONIT
МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН

Plitonit Deutsche Qualität

## PLITONIT SuperElast ус тусгаарлагч мембран




Уг бүтээгдэхүүн нь сул цементэн суурь, модон суурь болон уртааш ачаалалтай, хагарах эрсдэлтэй бусад суурь дээр өнгөлгөөний хавтан бүрээсийг суурилуулахад ус үл нэвтрүүлэгч, тусгаарлагч эсвэл ус үл нэвтрэх-тусгаарлах давхаргыг суурилуулах зориулалттай.

Ашиглалтын явцад хавтан дээр цуурал (3 мм-ээс ихгүй) үүссэн тохиолдолд хавтан хагарахаас сэргийлэхийн тулд мөн ашигладаг.

**Савлагаа — 10 м**

- Гадна болон дотоод ажилд (-30 °C хэмээс + 90 °C хэм хүртэл)
- 2,5 Атм хүртэлх илүү усны даралтыг тэсвэрлэнэ
- Суурийн 3 мм хүртэлх хагарлыг таглах
- Орон сууцны болон худалдааны зориулалттай
- Усан сан, усан хадгалагчийн хувьд

**Хэрэглээ**

Мембраныг хатуу суурийн хувьд С2 зэрэглэлээс багагүй, хэв гажилттай (OSB, гөлтгөнө хавтан гэх мэт) суурьт С2 S1 эсвэл C2S2-ээс багагүй ангиллын хавтангийн цавуу ашиглан суурь дээр суурилуулна.

Суурь дээр цавуу түрхэхийн өмнө тоосыг арилгаж, гадаргуут Plitonit хөрсжүүлэгчээр тухайлбал Plitonit Primer Бэхжүүлэгч эсвэл Plitonit хөрсжүүлэгч 1 түрхэнэ. 4 мм-ийн ховилтой хусуур ашиглан суурь дээр цавуу түрхэж, өнхрүүлгийн богино хажуугийн дагуу ховил үүсгэнэ. Мембраныг суурь дээр байрлуулж, гөлгөр хусуураар илэн мембраны доорх агаарыг зайлуулна. Дараагийн хоёр дахь эгнээг хоёр аргын аль нэгээр нь тавьж болно:

1. 7 см-ийн туузан дээр аль хэдийн тавьсан хуудасны ирмэг дээр уснаас тусгаарлагч шаваас түрхэж, эхнийхтэй нь 7 см-ийн давхцуулан мембраны хоёр дахь эгнээ тавина; 2. Хоёр дахь эгнээний мембраныг эхний үетэй холбосон хэсэгт байрлуулж, хоёр эгнээний давхаргыг ус тусгаарлагч шаваасаар бүрж, нийлсэн үеийг Plitonit Гидролента SuperElast ус үл нэвтрэх туузаар бүрхэнэ.

АНХААРУУЛГА! Мембраныг хананд тулгаж тавихаас давхарлаж тавихгүй. Булангийн хамгаалалтад ус тусгаарлагч шаваас болон Plitonit Гидролента SuperElast ашиглана. Дараагийн өнгөлгөөний ажил 72 цагийн дараа хийж болно. Цаашдын өнгөлгөөний ажилд хатуу суурinд C2-оос багагүй, хэв гажилттай (OSB, гөлтгөнө хавтан гэх мэт) суурьт C2 S1 эсвэл C2 S2-аас багагүй зэрэглэлтэй цавуу хэрэглэнэ.

**Найрлага:** полипропилен, полиэтилен

**Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл**

Ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг хангасан битүүмжилсэн газар хадгална. Бүтээгдэхүүний хадгалах хугацаа нь үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24 сар байна. Үйлдвэрлэсэн огноог баглаа боодол дээр зааж өгсөн болно.

**Чухал зөвлөмжүүд**

PLITONIT Ус үл нэвтрүүлэгч, тусгаарлах мембраныг Plitonit C, Plitoflex 2500, Plitoflex 5000 цавуу, полимер цемент уян харимхай ус тусгаарлагч PLITONIT ГидроЭласт 2К, түүнчлэн уян хатан ус тусгаарлагч хальсны Plitonit Гидролента SuperElast бүхий системд хамт ашигладаг.

**Үзүүлэлтүүд**

Өргөн: 1000 мм
Урт: 10 м
Зузаан: ~0,9мм
Талбай: 10м$^2$
Суурийн хагарлыг таглах: 3 мм хүртэлх
Ашиглалтын температур: -30°C ...+ 90°C
>2,5 Атм хүртэлх усны даралтыг тэсвэрлэнэ

Хувийн бар-код 4607013048867

**Суурилуулах заавар**

| | |
|---|---|
|  | 4 мм-ийн ховилтой хусуур ашиглан суурь дээр цавуу түрхэж, өнхрүүлгийн богино хажуугийн дагуу ховил үүсгэнэ |
|  | Мембраныг суурь дээр байрлуулж, гөлгөр хусуураар илэн мембраны доорх агаарыг зайлуулна |
|  | Хоёр дахь эгнээний мембраныг эхнийхтэй нь холбож, хоёр эгнээний мембраныг ус тусгаарлагч шаваасаар бүрж, үеийг Plitonit Гидролента SuperElast ус үл нэвтрэх хальсаар хучих эсвэл аль хэдийн тавьсан хуудасны ирмэг дээр 7 см-ийн туузаар ус тусгаарлагч шаваас түрхэж, мембраны хоёр дахь эгнээг эхний 7 см давхцуулж тавина |
|  | Мембраныг хананд тулгаж тавихаас давхарлаж тавихгүй. Булангийн хамгаалалтад ус тусгаарлагч шаваас болон Plitonit Гидролента SuperElast ашиглана |